

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН МЭДЭЭ

НЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн 2 дугаар хуралдаан 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдөр хуралдаж, танхимд 33 төлөөлөгч, цахимаар 6 төлөөлөгч оролцож, 95.12 хувийн ирцтэй хуралдлаа. Хуралдаанд 18 сумын удирдлага цахимаар оролцлоо. Тус хуралдаанаар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны дэгийг шинэчлэн батлах тухай, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх хороодын ажиллах журам, чиг үүрэг, бүрэлдэхүүн батлах тухай, аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай, 2021 оны төсөв батлах тухай, Газар нутгийг тусгай хамгаалалтад авах тухай, зарим газар нутгийг бичил уурхайн зориулалтаар аймгийн тусгай хэрэгцээнд авах тухай, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай, нийт 8 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

“Ковид 19” цар тахлын үед ковид болон бусад халдварт өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сангийн Ус хангамж, ариун цэвэр эрүүл ахуйн хөтөлбөрөөс 24.3 сая төгрөгийн нэн шаардлагатай эрүүл ахуйн тоног төхөөрөмж, нэг удаагийн хамгаалах хэрэгслийг аймгийн онцгой комисс, Эрүүл мэндийн салбарын байгууллагууд, Цагдаагийн газар, Онцгой байдлын газарт хүлээлгэн өглөө.

Үйлчилгээний нэгдсэн төв нь 162 нэр төрлийн үйлчилгээг 1400 иргэнд үзүүлсэн байна. Тус төвөөр үйлчилгээ авсан 680 иргэнд холбогдох зөвлөгөө мэдээллийг өгч ажиллалаа.

Тайлант хугацаанд 18 өргөдөл ирснээс 15 өргөдлийг шийдвэрлэж 3 өргөдлийн хугацаа болоогүй судлагдаж байна. Шийдвэрлэлт нь 83.33 хувьтай байна.

“Иргэдээ сонсох нээлттэй утас 7048-1111” дугаарын утсанд 54 дуудлага хүлээн авснаас, хувийн мэдээллээ бүрэн өгч “E-Office” программд бүртгэгдсэн 22 өргөдлийг холбогдох байгууллагуудад шилжүүлэн шийдвэрлүүллээ. Хугацаа болоогүй судлагдаж байгаа 4 өргөдөл байгаа бөгөөд шийдвэрлэлт 81.8 хувьтай байна.

Төрийн үйлчилгээний нэгдсэн системээс 269 лавлагааг олгож, төсөвт 207.0 мянган төгрөгийг төвлөрүүллээ.

Дэлхий нийтийг хамарсан цар тахлын үед хоёр орны аж ахуй нэгж, байгууллагын хамтын ажиллагааг өргөтгөх, экспорт, импортын худалдааг нэмэгдүүлэх зорилгоор БНХАУ-ын ШУӨЗО-ны Худалдааны газраас 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдөр онлайн хурал 2 үе шаттай зохион байгуулагдаж, эхний шатанд аймгийн Засаг даргын орлогч аймгийн эдийн засаг, хөрөнгө оруулалтын өнөөгийн байдал, цаашид хамтран ажиллах боломжтой салбарын талаар мэдээлэл хийлээ.

Хурлын 2 дугаар шатанд тус аймагт үйл ажиллагаа явуулж байгаа 10 аж ахуй нэгж, аймгийн Худалдаа, аж үйлдвэрийн тэнхим оролцож, хятад компаниудтай харилцан мэдээлэл солилцлоо.

Ерөнхий сайдын аймгийн Засаг даргатай байгуулсан батламжийн, Шадар сайд болон Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын аймгийн Засаг даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээ, 10 яамны сайдтай байгуулсан гэрээ, Үндэсний хөгжлийн газрын даргатай хөгжлийн бодлого төлөвлөлтийн чиглэлээр хамтран ажиллах гэрээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, хүргүүлээ.

Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний ажлын хөтөлбөрийн дагуу Говь-Алтай аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд цаг уурын 6 өртөөнд 3 цаг тутамд, цаг уурын 14 харуулд 8 цаг тутамд дэлхийн цаг уурын байгууллагын хөтөлбөрийн дагуу агаарын даралт, агаар, хөрсний гадаргын температур, агаарын чийгшил, хур тунадас, салхи, цасан бүрхүүлийн тархац ба зузаан (цас тогтсон үед), агаарын үзэгдэлд байнгын ажиглалт хийж байна.

Алтайн хүдэр-ХХК болон Майн Бласт ХХК-ны хүсэлтээр 2020 оны 12 дугаар сарын 16-20-ны өдрүүдэд “Алтайн хүдэр” ХХК-ны Таян нуурын уурхай болон Майн Бласт ХХК-ийн тэсрэх бодисын үйлдвэр агуулахын цогцолборын орчны нийт 12 цэгийн агаараас азотын давхар исэл /NO₂/, хүхэрлэг хий /SO₂/, том ширхэглэгт тоосонцор /PM10/, нарийн ширхэглэгт тоосонцор /PM2.5/-ын, нийт 12 цэгээс хөрсний дээж авч Байгаль орчны шинжилгээний лабораторид шинжиллээ.

ХОЁР. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Аймгийн Засаг дарга тайлант хугацаанд 44 захирамж гаргаж, ил тод нээлттэй байдлыг хангах зорилгоор аймгийн албан ёсны www.govi-altai.gov.mn сайтад байршууллаа.

Бигэр, Цээл, Халиун сумдын Засаг даргын нийт 114 захирамжийн эрх зүйн үндэслэл, албан хэрэг хөтлөлтийн стандартад хяналт тавьж, хэрэгжилтийг ханган ажиллалаа.

Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор хэлтэс, агентлаг, сумдын Засаг дарга нарт аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 12 дугаар сарын 09-ны өдрийн 3/1753 дугаар албан бичгээр захиргааны шийдвэр гаргахад анхаарах асуудлын талаар зөвлөмж хүргүүлээ.

Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Монгол Улсын хуулиудаас захиргааны хэм хэмжээний акт гаргах хуулиар тусгайлан эрх олгогдсон заалтын судалгааг гаргаж, сумдын Засаг дарга болон байгууллагын дарга нарт хүргүүлэн Захиргааны хэм хэмжээний актыг хуулийн хугацаанд Хууль зүй, дотоод хэргийн яаманд хянуулан, бүртгүүлж ажиллах тухай зөвлөмжийг албан бичгээр хүргүүлэн, хэрэгжилтийг ханган ажиллалаа.

Авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, иргэд олон нийтэд авлигын хор аюулыг ухуулан таниулах, олон нийтийг авлигатай тэмцэх арга барилд сургах, тэднийг татан оролцуулах хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх хүрээнд “Зөв зөвд шударга зөв” аяныг зохион байгуулж, ажлын тайланг Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэст хүргүүлээ.

Архивын тасаг: Архивын баримтаас иргэдийн хүсэлтийн дагуу 248 иргэнд мал тооллогын болон цалингийн лавлагаа, тушаалын хуулбар олгон 3827.5 мянган төгрөгийг төвлөрүүллээ.

Цаг үеийн нөхцөл байдалтай холбоотойгоор иргэдийн лавлагаа авах хүсэлтийг цахимаар болон утсаар хүлээн авч, 506 иргэний лавлагаанд хайлт хийж, нийт 4640 хуудас баримтыг хувилж хүргүүллээ.

Эрүүл мэндийн газар, Боловсрол соёл, урлагийн газрын харьяа байгууллагын удирдлагууд, архив, бичиг хэргийн ажилтнуудад 12 сарын 21, 22-ны өдрүүдэд онлайн сургалт зохион байгуулж, 220 албан хаагч хамрагдаж, мэдлэг чадвараа дээшлүүллээ.

Ашиглалтад орсон 8 барилгын холбогдох баримт бичиг болон Онцгой байдлын газрын 2005-2010 оны 32 хадгаламжийн нэгжийг хүлээн авч сан хөмрөгт нөхөн бүрдүүлэлт хийлээ. Мөн Цогт сумын Баянтоорой тосгоны нарны станцын өргөтгөл, 0,4 квтын цахилгааны шугамын ажлыг хүлээж авах улсын комиссын онлайн хуралд оролцож, ажлын гүйцэтгэлийн холбогдох баримт бичгийг Төрийн архивын сан хөмрөгт шилжүүлэх талаар санал, зөвлөгөө өгч ажиллалаа.

Архивын ерөнхий газраас 01/726 дугаар албан бичгийн дагуу нэмэгдэх орон тоо, шаардагдах төсвийн тооцооллыг гаргалаа.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар:Тайлант хугацаанд 29 гүйцэтгэх хуудасны 687793.9 мянган төгрөгийг төлбөр авагчийн хүсэлтээр буцааж, 5 гүйцэтгэх хуудасны 36513.5 мянган төгрөгийг харъяаллын дагуу шилжүүлж, 1 гүйцэтгэх хуудасны 359674.9 мян төгрөгийг шүүгчийн захирамжаар түдгэлзүүлэн, 272 гүйцэтгэх баримт бичгийн 2116699.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа бөгөөд биелэлт 56.0 хувьтай байна.

Хүүхдийн тэтгэлгийн 145 гүйцэтгэх хуудасны 397307.3 мянган төгрөгийн гүйцэтгэх баримт бичиг бүрт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж, 4 хүүхдийн тэтгэлэг төлөгчийн 2963.7 мянган төгрөгийн тэтгэлгийг харъяаллын дагуу шилжүүлж, 2 хүүхдийн тэтгэлэг төлөгчийн 3720.9 мянган төгрөгийн тэтгэлгийг тэтгэлэг авагчийн хүсэлтийн дагуу буцаах ажиллагаа явуулан, 8 гүйцэтгэх хуудасны 24064.1 мянган төгрөгийн тэтгэлэг бүрэн төлөгдөж, 9 гүйцэтгэх хуудасны 24340.4 мянган төгрөгийн тэтгэлгийг талууд эвлэрснээр дуусгавар болж, 5 гүйцэтгэх хуудасны 32456.4 мянган төгрөгийг тэтгэлэг авагч авахаас татгалзаж, 2 гүйцэтгэх хуудасны 3350.0 мянган төгрөгийн тэтгэлэг авагч хүүхэд 18 насанд хүрч, 1 хүүхдийн тэтгэлэг төлөгч нас барснаар гүйцэтгэх хуудсыг дуусгавар болгон хааж, 90 тэтгэлгийн 198039.7 мянган төгрөгийг хэсэгчлэн гаргуулж, 113 гүйцэтгэх баримт бичгийн 101183.8 мянган төгрөгийн тэтгэлгийн үлдэгдэлтэй, биелэлт 74.0 хувьтай байна.

Мөн “Төлбөртэй хоригдлын нэгдсэн бүртгэл хөтлөх, хяналт тавих журам”-ын хэрэгжилтийг хангах зорилгоор тус газарт 13 төлбөртэй хоригдлын гүйцэтгэх баримт бичиг байгаагаас 6 хоригдлын хөдөлмөрийн хөлснөөс сар бүр суутгасан төлбөрийн мөнгийг төлбөр авагчид шилжүүллээ.

Хорих ангид ял эдлэж байгаа 7 хоригдлын 10 гүйцэтгэх хуудасны 3280.4 мянган төгрөгийн хохирол гаргуулахыг бүрэн дуусгаж, 5 хоригдлын 15 гүйцэтгэх хуудасны 12934.2 мянган төгрөгийн төлбөрийг гаргуулж, 43 гүйцэтгэх хуудасны 96415.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

ГУРАВ. ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ, САНХҮҮ, ХУДАЛДАН АВАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

Орон нутгийн төсөвт 7905.6 сая төгрөг төвлөрүүлэхээс 9110.3 сая төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөг 115.2 хувиар биелүүллээ. Төсвийн хуваарийн дагуу орон нутгийн төсвийн байгууллагуудад 21914.2 сая төгрөг, Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудад 38591.3 сая төгрөг, Орон нутгийн хөгжлийн санд 7293.0 сая төгрөгийн санхүүжилтийг батлагдсан төсвийн хуваарийн дагуу бүрэн олголоо.

Төсөвт байгууллагуудын зарлагын гүйлгээг баримтын бүрдэл, дансны үлдэгдэл, эдийн засгийн ангиллын дагуу хянаж, 3091 ширхэг төлбөрийн хүсэлтээр 12132.1 сая төгрөгийн төлбөр тооцооны гүйлгээг хийж, орон нутгийн төсвийн орлогын дансны үлдэгдлийг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Орон нутгийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүллээ.

Улсын төсвийн хөрөнгөөр Бугат сумын Цэвэр усны шугам сүлжээний шинэчлэл, засварын ажлын худалдан авах ажиллагаа зохион байгуулж, гүйцэтгэгчээр шалгарсан “Баялаг-Говь” ХХК-д гэрээ байгуулах эрх олголоо.

ДӨРӨВ. ХӨДӨӨ АЖ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР

НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагад тусламжид хамрагдах Бигэр, Бугат, Тонхил, Төгрөг, Халиун, Цогт, Цээл, Чандмань, Эрдэнэ, Есөнбулаг сумдын зорилтот бүлгийн малчин өрхийн судалгаа, 18 сумын хонин толгойд шилжүүлснээр 300-аас доош малтай малчин өрхийн судалгаа, 2018, 2019 онд арьс шир, ноос бэлтгэн тушаасан овог, нэр, регистр зөрүүтэй байсан 44 малчны мэдээллийг тус тус нэгтгэн ХХААХҮЯаманд хүргүүллээ.

Халиун, Жаргалан сумдын Ёлтон, Цахирын услалтын системийн байгаль орчны үнэлгээ хийлгэх хүсэлтийг Байгаль орчин аялал жуулчлалын яаманд албан бичгээр хүргүүллээ.

ЖДҮХС-аас зээл авахаар шалгарсан 5 аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан, 474.0 сая төгрөгийн санхүүжилтийг олголоо.

Аймгийн хэмжээнд мал тооллогын ажил явагдаж эхэлсэнтэй холбоотой хяналтын тооллогыг Шарга, Хөхморьт, Баян-Уул сумдад зохион байгууллаа.

ТАВ. БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТ, ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ ЧИГЛЭЛЭЭР

Газрын харилцааны чиглэлээр: Газар зохион байгуулалтын 2020 оны төлөвлөгөөний биелэлтийг газрын удирдлагын цахим системд оруулж, биелэлт 69.3 хувьтай байгаа бөгөөд 2021 оны сумын газар зохион байгуулалтын батлагдсан төлөвлөгөөг цахим системд орууллаа.


Аймгийн Засаг даргын захирамжаар 4 байгууллагад үйлчилгээний зориулалтаар, 8 иргэнд орон сууц, гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар тус тус газар эзэмших эрхийн гэрчилгээ олгож, гэрээ байгууллаа.

Аймгийн хэмжээнд газар эзэмших хүчинтэй 11684 нэгж талбар, газар өмчлөлийн хүчинтэй 6776 нэгж талбар, ашиглах эрхийн 28 нэгж талбарын газрын төлбөр, татварын ногдуулалтыг хийж нийт хүчинтэй гэрээний 98.0 хувьд нь ногдуулалт хийж, ногдуулалт үүсгэсэн нэгж талбаруудаас 4407 газар эзэмшигч, ашиглагчийн төлөлт бүртгэгдэж, газрын төлбөрийн орлого 320.6 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж 72.2 хувийн биелэлттэй байна.

Газар эзэмшүүлэх гэрээг дүгнэх ажлын хүрээнд нийт 11712 газар эзэмшигч, ашиглагч байгаагаас одоогийн байдлаар 3627 газар эзэмшигчийн гэрээг дүгнэж ажлын явц 30.9 хувьтай байна. Дэлхий нийтээр тархсан цар тахлын улмаас олон нийтийг хамарсан ажлын хэрэгжилт удаашралтай байгаа болно.

2020 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд 71 байршилд газарт эзэмших эрхийн дуудлага худалдааг зохион байгуулахаар төлөвлөснөөс 39 байршил газарт амжилттай зохион байгуулан, орон нутгийн төсөвт 226.8 сая төгрөг төвлөрүүллээ.

Барилга угсралтын чиглэлээр: Тайлант хугацаанд улсын төсвийн 2,100.0 сая төгрөгийн санхүүжилтээр Цагдаагийн барилга угсралтын ажлыг, 40.0 сая төгрөгийн санхүүжилтээр Дэлгэр сумын Гуулин тосгоны гэрэлтүүлэг тохижилтын, 45.0 сая төгрөгийн санхүүжилтээр Дэлгэр сум Гуулин тосгоны ерөнхий боловсролын сургуулийн засварын, орон нутгийн хөгжлийн сангийн 40.0 сая төгрөгийн санхүүжилтээр Есөнбулаг сумын инженерийн шугам сүлжээний 100 ширхэг траншейг тагжуулах, гуу жалгыг тэгшлэх ажлыг, 30.0 сая төгрөгийн санхүүжилтээр Хөхморьт сумд инженерийн хийцтэй худаг гаргах ажлыг, хувийн хөрөнгө оруулалтаар Тонхил, Төгрөг сумдын төрийн банкны тооцооны төвийн барилга угсралтын ажлыг тус тус байнгын ашиглалтад орууллаа.



Барилгын материал лабораторийн 2020 оны үйл ажиллагааны болон Барилгын хөгжлийн төвтэй байгуулсан гэрээний хэрэгжилтийн тайлан, “Төрөөс орон сууц, нийтийн аж ахуйн талаар баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг тус тус гарган, албан бичгээр холбогдох байгууллагуудад хүргүүллээ.

Нийтийн аж ахуй талаар: 2020 оны 12-р сарын 15-ны байдлаар 6 гүний худагтайгаар үйл ажиллагаагаа явуулж, 26660 м3 ус олзворлон түгээллээ.

Нийт 21419 м3 усыг даралтат усан санруу шахаж, насос станцын хлоржуулах төхөөрөмжөөр 3 удаагийн хлорыг 3.6 кг гипохлороор цэвэр усанд тавьж ажиллалаа.

Цэвэрлэх байгууламжид 21669 м3 бохир усыг цэвэршүүлсэн бөгөөд 12.6 м3 усанд уусаагүй хольц буюу овор хэмжээ ихтэй хог хаягдлыг татан зайлуллаа.

Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан 124 удаа ус түгээх худаг болон цистернд 70 удаа халдваргүйжүүлэлт хийлээ. Цэвэрлэх байгууламжийн усыг хүлээн, 2 цаг тутамд ариутгал халдваргүйжүүлэлт хийж бүх нийтийн бэлэн байдлын үед 150 кг хлорын шохойгоор ариутган халдваргүйжүүллээ.

Есөнбулаг сумын Жаргалант, Түмэн, Харзат Баяншанд багуудын айл өрхүүдэд ус түгээж буй 8-н зөөврийн усан сан болон усны тээврийн 3 авто машиныг халдваргүйжүүлж, ариутгалыг улиралд 1-2 удаа төлөвлөгөөний дагуу жавелионы уусмалаар зохих заавар журмын дагуу халдваргүйжүүлэлт хийж байна.

Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 12 дугаар сарын 18-ны 242 тоот тушаалаар батлагдсан "Цэвэр, бохир усны хэрэглээг зохицуулах түр журам" болон "Төрөөс хариуцах цэвэр, бохир усны төлбөр тооцоог зохицуулах түр журам"-ын дагуу ундны 22 ус түгээх худаг, зөөврийн болон орон сууцны хэрэглэгчдийн усны үнийг тэглэсэн ба зохих хэрэглээтэй холбоотой усны алдагдал хоногт 82,9м3 байна.

ЗУРГАА. НИЙГМИЙН САЛБАР:

Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбоотой ажлууд: Шуурхай штабыг Эрүүл мэндийн газарт байршуулан Онцгой байдлын газар, Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Есөнбулаг сумын ЗДТГ-ын албан хаагчид 24 цагаар жижүүрлэн, үүрэг гүйцэтгэн ажиллаж байна.

12 дугаар сарын 3-ны өдрөөс 18-ний өдрүүдэд өдөр бүр аймгийн шуурхай штабын мэдээллийг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр иргэдэд мэдээллээ. Есөнбулаг сумын гэрийн ажиглалтын хугацаа дууссан иргэдээс түргэвчилсэн оношлуураар 534 хүнд шинжилгээ хийж, хариу сөрөг гарлаа.

Аймгийн Засаг даргын 2020 оны А/687 захирамжаар гамшгийн сангийн 20.0 сая төгрөгөөр 6 нэр төрлийн 20400 ширхэг хамгаалах хувцас хэрэгслийн нөөцийг бүрдүүллээ.

ЭМЯ-наас Дарив сумын ЭМТ, Жаргалан-Алтай, Марал-Алтай, Энх-Алтай өрхийн Эрүүл мэндийн төвд түргэн тусламжийн автомашин хүлээлгэн өглөө.

НҮБ-ын Хүүхдийн сангийн Ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн хөтөлбөрийн 11.2 сая, орон нутгийн хөгжлийн сангийн 5.1 сая, нийт 16.3 сая төгрөгийн санхүүжилтээр аймгийн Нэгдсэн эмнэлэгт аюултай хог хаягдал бутлагч тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл худалдан авлаа.

Аймгийн хэмжээнд 2020 оны эхний 11 сарын байдлаар 1288 эх нярайлж өнгөрсөн оны мөн үеэс 33 тохиолдол буюу 2.6 хувиар, 1300 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 31 хүүхдээр буюу 2.4 хувиар тус тус өссөн, нас баралтын 257 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 16 тохиолдлоор буурсан

үзүүлэлттэй байна. Эрсдэлт бүлгийн хүн амын буюу 9411 хүний судалгааг авч нэгтгэн ЭМЯ-нд хүргүүллээ.

Боловсрол, соёл, урлагийн чиглэлээр: Үнэлгээний төвөөс 2020 оны 12 сарын 15-18-ны өдрүүдэд зохион байгуулж буй "Үнэлгээний шинжээч багш-2" онлайн сургалтад 2 мэргэжилтэн, НҮБ-ын Хүүхдийн сан, Онцгой байдлын газраас 2020 оны 12 сарын 15, 16-ны өдрүүдэд зохион байгуулсан "Хүүхэд төвтэй гамшгийн эрсдлийн төлөвлөгөө боловсруулах аргачлал" сургалтад 2 мэргэжилтэн тус тус хамрагдаж, чадавхжлаа. Аймгийн Гамшгаас урьдчилан сэргийлэх төлөвлөгөө болон НҮБ-ын Хүүхдийн сангийн хүүхэд төвтэй гамшгийн эрсдлийн 2021 оны төлөвлөгөөг боловсрууллаа. Боловсролын ерөнхий хуулийн онлайн хэлэлцүүлэгт сургууль, цэцэрлэгүүдийн 25 нэгжээс оролцож, гарсан саналыг нэгтгэн Боловсрол, шинжлэх ухааны яаманд хүргүүллээ.

Бага ангийн сурах бичгийн хангалт 98.8 хувь, дунд ахлах анги 88.1 хувь байна.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн чиглэлээр: Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль тэдгээрийг дагаж гарсан журмуудын хэрэгжилт, гишүүдийн хуулиар хүлээсэн үүрэг, хариуцлага, оролцоо, хариу үйлчилгээний чанар хүртээмж, хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнг үнэлж, дүгнэх, шагнаж урамшуулах, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор "Гэр бүл, хүүхдэд ээлтэй хамтарсан баг"-ийн 2020 оны ажлыг дүгнэхэд аймгийн 29 хамтарсан баг, 266 гишүүнийг хамруулан зохион байгуулж, дүнгээ гаргалаа.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын чиглэлээр төрөөс баримталж буй бодлого, хууль тогтоомж, дүрэм журмуудын хэрэгжилт болон хамтарсан багийн гишүүдийн хуулиар хүлээсэн үүрэг хариуцлага, хариу үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, чадавхжуулах зорилгоор "Хариуцлагатай хамтарсан баг" сургалтыг 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрөөс 18-ны өдрүүдэд цахим хэлбэрээр зохион байгуулж, нийт 18 сумын 29 хамтарсан багийн 210 гишүүн оролцож, мэдлэг чадвараа дээшлүүлэн чадавхжлаа.

Төр, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагуудын "Эцэг эхийн зөвлөл"-ийн үйл ажиллагаа, үр дүнгийн тайлан мэдээг хүлээн авч шалгуур үзүүлэлтийн дагуу 2020 оны "Шилдэг эцэг эхийн зөвлөл"-ийг шалгаруулж батламж, мөнгөн шагнал, байгууллагын эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагааны самбарыг гардууллаа.

Өрх гэр, ажлын байр, олон нийтийн газарт хүчирхийлэл айдасгүй, амар амгалан орчинг бий болгохын төлөө олон нийтэд хандсан санаачилга, ухуулга нөлөөлөл, мэдлэг мэдээллийг цахим орчинд түгээх зорилгоор Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аяныг зохион байгуулж, аяны хүрээнд байгууллагын цахим хуудсаар 16 удаагийн зөвлөмж мэдээлэл бүхий постерыг 6245 иргэнд, 9 удаагийн видеог – 5027 иргэнд, нийт 11272 иргэнд мэдээлэл хүргэн ажиллалаа. Мөн гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, мэдээлэх, үйлчилгээ авах зөвлөмж бүхий сурталчилгааны материал, гарын авлага, нийт 1000 ширхэгийг хэвлүүлэн олон нийтийн үйлчилгээний газруудад байршуулан иргэдэд түгээж ажиллалаа.

Улсын хэмжээнд гамшгаас хамгаалах бэлэн байдалд шилжүүлж ковид-19 цар тахал нийтийг хамарсан хатуу хөл хорио тогтоосонтой холбогдуулан гэр бүлтэйгээ халуун дулаан уур амьсгалыг нэмэгдүүлэн, гэр бүлийн эерэг харилцааг бэхжүүлэх, чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх, нийгэмд эерэг хандлага түгээх зорилгоор “Эгшиглэнт шинэ жил” цахим дууны уралдааныг зохион байгууллаа.

Шинээр их дээд сургууль төгссөн залуучуудыг байнгын ажлын байраар хангасан шилдэг ажил олгогч байгууллагыг шалгаруулан урамшууллаа.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний чиглэлээр: 2020 оны 12 дугаар сарын нийгмийн халамжийн сангаас дараах тэтгэвэр тэтгэмжийн санхүүжилтийг олголоо. Үүнд: Халамжийн тэтгэвэр 1403 иргэнд 392.7 сая төгрөг, нөхцөлт мөнгөн тэтгэмж 1105 иргэнд 98.6 сая төгрөг, амьжиргаа дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмж 990 иргэнд 106.6 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт, тусламж 145 иргэнд 15.6 сая төгрөг, ахмад настны хөнгөлөлт, тусламж 115 иргэнд 33.1 сая төгрөг, алдар цолтой ахмадын хөнгөлөлт 30 иргэнд 5.3 сая төгрөгийн нийгмийн халамжийн үйлчилгээг тус тус үзүүллээ.

Нийгмийн даатгалын чиглэлээр: Нийгмийн даатгалын сангаас үйлчилгээ авагч иргэдийн тэтгэврийг 12 дугаар сарын 01-нд багтаан олгож, олгогдоогүй тэтгэвэр тэтгэмжийн өглөггүй ажиллалаа.

Аймгийн хэмжээнд өндөр насны тэтгэвэр авагч 8661 хүнд 3219.2 сая төгрөгийг олголоо. Шинээр тэтгэвэр тогтоолгосон хүсэлт гаргасан өндөр настан 76, тахир дутуу 13, тэжээгчээ алдсаны тэтгэвэр 3, нийт 92 даатгуулагчийн тэтгэврийн баримт материалыг хүлээн авч хуулийн хүрээнд шийдвэрлэлээ.

Тэтгэмжийн даатгалын сангаас жирэмсэн амаржсаны тэтгэмж 84 хүнд 131.7 сая, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж 56 хүнд 9.2 сая, оршуулгын тэтгэмж 20 хүнд 20.0 сая, ажилгүйдлийн даатгалын сангаас ажилгүйдлийн тэтгэмжид 71 даатгуулагчид 40.6 сая төгрөгийг тус тус олголоо. Сайн дурын даатгалд нийт 133 хүн хамрагдсанаас 112 хүн ажилгүй, 0-3 насны хүүхдээ асарч буй 21 эхийг хамрууллаа.

Эрүүл мэндийн даатгалд 565 иргэн хамруулж, 30.2 сая төгрөг ЭМД-ын санд хуримтлагдлаа.

Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын хурлаар 297 хүн орж, үүнээс шинээр-29 хүн хөдөлмөрийн чадвар алдалт тогтоолгож, 264 хүний групп сунгагдлаа. 3 хүн цуцлагдлаа.

Нийгмийн даатгалын шимтгэл төлөлттэй холбоотой лавлагааг 63 хүнд гаргаж өглөө.

ДОЛОО. БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЧИГЛЭЛЭЭР

Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас батласан “Гар аргаар ашигт малтмалын улмаас эвдрэлд орсон газрын талбайн хэмжилт, хяналт шалгалт хийх удирдамж”-ийн хүрээнд Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга Г.Болдбаатараар ахлуулсан ажлын хэсэг Алтай, Бигэр, Цогт, Эрдэнэ, Чандмань сумдад 2020 оны 12 сарын 11-ний өдрөөс 15-ны өдрүүдэд ажиллаж, 2020 оны үйл

ажиллагааг шалган, тулгамдаж буй асуудлын талаар санал хүсэлтийг сонсон, заавар зөвлөгөө өглөө.

Мөн Алтай, Эрдэнэ сумын нутагт байрлалтай дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлт болон хүний хүчин зүйлийн нөлөөнөөс газрын доройтолд өртөж буй Майхан булаг болон Их Зармангийн баянбүрдүүдийг нөхөн сэргээж, хашиж хамгаалах, Цогт сумын Баянтоорой тосгонд ГИДЦГ-ын А хэсгийн хамгаалалтын захиргааны хариуцаж буй мод үржүүлгийн талбайн нөхцөл байдал үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж талбай доторх усалгааны зориулалтаар ашиглах боломжтой хуучин хөвийг сэргээх, усалгааны асуудлыг сайжруулах зэрэг ажлуудад хэмжилт хийн, үндэслэл, тооцоо судалгааг гарган боловсруулж, шаардагдах санхүүжилтийг 2021 онд “Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд хэрэгжиж буй олон улсын төсөл хөтөлбөрөөс шийдвэрлүүлэхээр Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүсэлтийг хүргүүлээ.

НАЙМ. ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

Дотоод ажлын зохион байгуулалтын талаар: Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын зохион байгуулсан 15 удаагийн цахим хурлаас өгөгдсөн 53 үүрэг даалгаврын 52 буюу 98.1 хувийн, 12 удаагийн шуурхай хурлаас өгөгдсөн 12 үүрэг даалгавар 100 хувийн хэрэгжилттэй байна.

Байгууллагын үйл ажиллагаа, хяналт шалгалтын ажил, үр дүнгийн талаарх мэдээ, мэдээлэл, зөвлөмж, сэрэмжлүүлгийг байгууллагын веб сайтад 323, аймгийн вэб сайтад 12, Facebook 387, орон нутгийн телевиз 65, радиод 25 удаагийн мэдээ мэдээллийг иргэдэд хүргэн ажиллалаа.

Цар тахалын үед зохион байгуулсан ажлын талаар: Ил задгай худалдаа явуулж байсан хүнсний 3, махны 8, хэвийн боовны 6 иргэний үйл ажиллагааг зогсоосон ба олон нийтийг хамарсан уулзалт, сургалт, семинар, ёслол хүндэтгэл, урлаг, спортын арга хэмжээ зохион байгуулсан зөрчил гараагүй болно.

Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд 23 удаа ЭМГ-ын мэргэжилтнүүдтэй хамтран хяналт шалгалт хийн бэлэн байдал хангаагүй байсан 5 байгууллагад 15 заалттай 5 зөвлөмж хүргүүлж, хэрэгжилтийг тооцон ажиллалаа.

Алтай хотын төвд байрлах 3 нэгдсэн нам даралтын 15 халаалтын зуухны даралт, температурын графикайг тухайн орон нутгийн гадна т⁰-тай уялдуулсан эсэх, тоног төхөөрөмж, шугам хоолой, ашиглалт, аюулгүй ажиллагааны зааврыг ажлын байранд байрлуулсан байдал, нэмэлт усны тоноглол, даралт, температурын хэмжих хэрэгслүүдийн суурилуулалт, ажиллаж байгаа ажилтнуудад ашиглалт, аюулгүй ажиллагааны заавар тогтмол өгч байгаа эсэхэд хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.



Байгаль орчин геологи уул уурхайн хяналтаар: 49 объектод хяналт шалгалт хийхэд 32 объект их, 6 объект дунд, 11 объект бага эрсдэлтэй үнэлэгдэж, илэрсэн зөрчлийг арилгуулахаар 235 заалт бүхий 13 албан шаардлага хүргүүлж, 8 аж ахуйн нэгж, 1 иргэнд 12.6 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, 36 буюу 72.5%-д

гүйцэтгэлийн хяналт хийлээ. Шалгалтад хамрагдсан объектуудын эрсдэл үүсэх магадлал 57.8%, хуулийн хэрэгжилт 44.4 %-тай байна.

Үр дүн: Хяналт шалгалтад хамрагдсан объектын хууль сахин мөрдөлтийн түвшинг 6.4 пунктээр, улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлтийг 3.4, зөрчил арилгуулалтын түвшинг 2.8 пунктээр, гүйцэтгэлийн хяналт шалгалтын түвшинг 4 пунктээр тус тус нэмэгдүүлж, хяналт шалгалтад хамрагдсан объектод их, дунд эрсдэлтэй объектын эзлэх хувийг 3.5 пунктээр бууруулж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр 4 удаа, 13 төрлийн зөвлөмж, сэрэмжлүүлэг боловсруулан иргэдэд мэдээллээ.

Дэд бүтцийн хяналтаар: Хяналтын 7 чиглэлээр 70 объектод хяналт шалгалтыг хийхээр төлөвлөснөөс 61 объектод хийхэд 11 объект их, 18 объект дунд, 32 объект бага эрсдэлтэй үнэлэгдэж, илэрсэн зөрчлийг арилгуулахаар 244 заалт бүхий 31 албан шаардлага хүргүүлж, 40 буюу 47.9%-д гүйцэтгэлийн хяналт хийлээ. Шалгалтад хамрагдсан объектуудын эрсдэл үүсэх магадлал 19.7%, хуулийн хэрэгжилт 80.6 %-тай байна.

Үр дүн: Хяналт шалгалтад хамрагдсан объектын хууль сахин мөрдөлтийн түвшинг 10.3 пунктээр, улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлтийг 5.6 пунктээр, зөрчил арилгуулалтын түвшинг 10 пунктээр, гүйцэтгэлийн хяналт шалгалтын түвшинг 10 пунктээр нэмэгдүүлж, хяналт шалгалтад хамрагдсан объектод их, дунд эрсдэлтэй объектын эзлэх хувийг 3.9 пунктээр бууруулж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр 9 удаа, 21 төрлийн зөвлөмж, сэрэмжлүүлэг боловсруулан олон нийтэд мэдээллээ.

Хөдөлмөр нийгмийн хамгааллын хяналтаар: 45 объектод хяналт шалгалтыг хийхээр төлөвлөснөөс 45 объектод хийж, 29 объект их, 12 объект дунд, 4 объект бага эрсдэлтэй үнэлэгдэж, илэрсэн зөрчлийг арилгуулахаар 289 заалт бүхий 10 албан шаардлага хүргүүлж, 31.8 сая төгрөгийн нөхөн төлбөр, 2.5 сая төгрөгийн торгууль ногдуулж, 28 буюу 73.3%-д гүйцэтгэлийн хяналт хийлээ. Шалгалтад хамрагдсан объектуудын эрсдэл үүсэх магадлал 51.5%, хуулийн хэрэгжилт 54.7 %-тай байна.

Үр дүн: Хяналт шалгалтад хамрагдсан объектын хууль сахин мөрдөлтийн түвшинг 16.3 пунктээр, улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлтийг 5.9 пунктээр, зөрчил арилгуулалтын түвшинг 6 пунктээр, гүйцэтгэлийн хяналт шалгалтын түвшинг 3.4 пунктээр нэмэгдүүлж, хяналт шалгалтад хамрагдсан объектод их, дунд эрсдэлтэй объектын эзлэх хувийг 4.7 пунктээр бууруулж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр 7 удаа, 24 төрлийн зөвлөмж, сэрэмжлүүлэг боловсруулан олон нийтэд мэдээллээ.

Цацрагийн хяналтаар: 1 объектод хяналт шалгалт хийхэд 1 дунд эрсдэлтэй үнэлэгдэж, илэрсэн зөрчлийг арилгуулахаар 6 заалт бүхий хамтарсан албан шаардлага хүргүүлж, бүрэн хэрэгжүүлж ажиллалаа. Шалгалтад хамрагдсан объектуудын эрсдэл үүсэх магадлал 27%-тай, хуулийн хэрэгжилт 64%-тай байна.

Үр дүн: Хяналт шалгалтад хамрагдсан объектын хууль сахин мөрдөлтийн түвшинг 12 пунктээр, улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлтийг 5.8

пунктээр, зөрчил арилгуулалтын түвшинг 8 пунктээр, гүйцэтгэлийн хяналт шалгалтын түвшинг 5 пунктээр нэмэгдүүлж, хяналт шалгалтад хамрагдсан объектод их, дунд эрсдэлтэй объектын эзлэх хувийг 2 пунктээр бууруулж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр 1 удаа, 2 төрлийн зөвлөмж, сэрэмжлүүлэг боловсруулан олон нийтэд мэдээллээ.

Эрүүл мэнд, боловсрол, соёлын хяналтаар: 107 объектод хяналт шалгалтыг хийхээр төлөвлөснөөс 105 объектод хийхэд 3 объект их, 50 объект дунд, 50 объект бага эрсдэлтэй үнэлэгдэж, илэрсэн зөрчлийг арилгуулахаар 898 заалт бүхий 57 албан шаардлага хүргүүлж, 1 аж ахуйн нэгжид 50.0 мянган төгрөгийн нөхөн төлбөр ногдуулж, 65 буюу 60.7%-д гүйцэтгэлийн шалгалт хийлээ. Шалгалтад хамрагдсан объектуудын эрсдэл үүсэх магадлал 19.95%, хуулийн хэрэгжилт 82.59%-тай байна.

Үр дүн: Хяналт шалгалтад хамрагдсан объектын хууль сахин мөрдөлтийн түвшинг 8.49 пунктээр, зөрчил арилгуулалтын түвшинг 3.0 пунктээр нэмэгдүүлж, гүйцэтгэлийн хяналт шалгалтын түвшин 0.5 пунктээр буурч, хяналт шалгалтад хамрагдсан объектод их, дунд эрсдэлтэй объектын эзлэх хувийг 5 пунктээр бууруулж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр 5 удаа, 15 төрлийн зөвлөмж, сэрэмжлүүлэг боловсруулан олон нийтэд мэдээллээ.

Хүнс, хөдөө аж ахуйн хяналтаар: 75 объектод шалгалт хийхээр төлөвлөснөөс 69 объектод хийхэд 1 объект их, 42 объект дунд, 26 объект бага эрсдэлтэй үнэлэгдэж, илэрсэн зөрчлийг арилгуулахаар 583 заалт бүхий 47 албан шаардлага хүргүүлж, 26 буюу 37.7%-д гүйцэтгэлийн шалгалт хийлээ. Шалгалтад хамрагдсан объектуудын эрсдэл үүсэх магадлал 23.79%, хуулийн хэрэгжилт 78%-тай байна.

Үр дүн: Шалгалтад хамрагдсан объектын хууль сахин мөрдөлтийн түвшинг 8.49 пунктээр, улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлтийг 3, зөрчил арилгуулалтын түвшинг 3 пунктээр нэмэгдүүлж, гүйцэтгэлийн хяналт шалгалтын түвшин 23.5 пунктээр буурч, хяналт шалгалтад хамрагдсан объектод их, дунд эрсдэлтэй объектын эзлэх хувийг 5 пунктээр бууруулж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр 5 удаа, 18 төрлийн зөвлөмж, сэрэмжлүүлэг боловсруулан олон нийтэд мэдээллээ.

ТӨЛӨВЛӨГӨӨТ БУС ХЯНАЛТААР: Байгаль орчин, дэд бүтэц, хөдөлмөрийн хяналтын чиглэлээр гомдол мэдээллийн мөрөөр 14 төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж, 24 заалт бүхий 4 албан шаардлага, 7 дүгнэлт үйлдэж, 6650.0 мянган төгрөгийн, харьяаллын дагуу шилжиж ирсэн зөрчлийг шалгаж, 1 аж ахуйн нэгж, 35 иргэнд 5400.0 мянган төгрөгийн торгууль ногдуулан, илэрсэн зөрчлийг арилгууллаа.

Эрүүл мэнд, боловсрол, хүнсний хяналтын чиглэлээр гомдол мэдээллийн мөрөөр 8 төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулан 1 иргэнд 500.0 мянган төгрөгийн шийтгэл ногдуулан бүрэн барагдууллаа.

